



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БУЛГАН АЙМГИЙН СЭЛЭНГЭ СУМЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: БУА-2026/6/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Булган аймаг

2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт

Утас: 70342716 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Намчинсүрэн

Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт	4
Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлт	6
Гурав. Аудитын илрүүлэлт	6
Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	7

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24. № 272

танай _____ ны № _____ т

СЭЛЭНГЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.УУГАНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Цагдаагийн кубон барилгын засварын ажлыг 54.1 сая төгрөгөөр гүйцэтгэхдээ зураг төсөвгүй, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

6326050376

Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулсан бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлууд байхгүй байна.

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газрын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 зорилт 36 арга хэмжээний хэрэгжилт 82.6 хувиар дүгнэсэн, хөтөлбөр арга хэмжээнд зориулан 1,304.3 сая төгрөгийг төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,257.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сэлэнгэ сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д. БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлт

		/мянган төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	86,875.5	91,448.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	939,912.2	1,289,742.4
	Нийт хөрөнгийн дүн	1,026,787.7	1,381,191.1
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,026,787.7	1,381,191.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,026,787.7	1,381,191.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,304,122.4	1,727,437.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,290,353.9	1,357,003.2
	Үйл ажиллагааны үр дүн	13,768.5	370,433.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	711.7	16,030.3
	Үйл ажиллагааны нийт үр дүн	13,056.8	354,403.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,026,787.7	1,026,787.7
	Тайлант оны үр дүн	-	354,403.4
	Эцсийн үлдэгдэл	1,026,787.7	1,381,191.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,212,397.0	1,257,880.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,211,197.1	1,228,356.0
	Үйл ажиллагааны ЦМГ	1,199.9	29,524.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(1,199.9)	(29,524.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(0.0)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	1,257,880.1
	Урсгал зардал	-	1,228,356.0
	Хөрөнгийн зардал	-	29,524.1
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,257,880.1
	Орон нутгийн төсвөөс	-	1,081,890.6
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	18,040.1
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	157,949.4

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 67.4 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 2.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 54.2 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 11.1 сая төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 13.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6.0 сая төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

5.1 Төлөрийн акт

1. Төрийн албан хаагчийн сул орон тоог түр орлон гүйцэтгэсэний цалинг 1.5 сая төгрөгөөр илүү тооцон олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5, Засгийн газрын 2019 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам", санхүүгийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Төсвийн хөрөнгөөр бэлэг дусгалын зүйл худалдан авахад нийт 0.5 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Зураг, төсөвгүй, худалдан авах ажиллагааны тендер зарлаагүйгээр Цагдаагийн кубоны засварын ажлыг 54.2 сая төгрөгөөр гүйцэтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй зөрчилд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засвар үйлчилгээ хийсэн бараа материал 3.4 сая төгрөгийг зарлагдаагүй үлдэгдэлээр тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6, санхүүгийн тайлангийн аудитын ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын хавсралтын дагуу зөв ангилан бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засвар үйлчилгээ хийсэн бараа материалыг зарлагдаагүй үлдэгдэлээр тайлагнасан.	1	3.4					1	3.4				

Төрийн албан хаагчийн сул орон тоог түр орлон гүйцэтгэсэний цалинг илүү тооцон олгосон.	1	1.5	1	1.5								
Засаг даргын нөөц хөрөнгөөс ахмадын баяраар ахмад настануудад хүндэтгэл үзүүлэх, мал тооллогын шатахуун зарцуулсан.	1	7.7					1	7.7				
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин бэлэг дурсгалын зүйлийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан.	1	0.5	1	0.5								
Зураг, төсөвгүй, худалдан авах ажиллагааны тендер зарлаагүйгээр Цагдаагийн кубоны засварын ажлыг гүйцэтгэсэн.	1	54.2			1	54.2						
Дүн	5	67.3	2	2.0	1	54.2	2	11.1	0	0	0	0